

УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМЫН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шүүхийн бус аргаар, эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах, эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёрдугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах төв

2.1. Улаанбаатар хотын Худалдааны Танхим /цаашид “УБХТ” гэх/-ын дэргэд эвлэрүүлэн зуучлах төв /цаашид “Төв” гэх/ ажиллана. Төв нь УБХТ-аас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэд, байгууллага хоорондын эдийн засаг, бизнесийн харилцаатай холбоотой иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

2.2. Маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх эрх гагцхүү эвлэрүүлэн зуучлагчид хадгалагдана.

2.3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хэлэлцээр, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, талуудын тохиролцсон хэлэлцээр, журам, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Гуравдугаар зүйл. Нэр томъёо

3.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “Эвлэрүүлэн зуучлал” гэж Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар;

3.1.2. “Тал” болон “Талууд” гэж эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг зохицуулах хүсэлт гаргасан эсхүл арбитр эвлэрүүлэн зуучлалыг зохистой гэж үзэж санал болгосныг зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлалд оролцох болсон зохигчийг;

3.1.3. “Эвлэрүүлэн зуучлагч” гэж Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т зааснаар;

3.1.4. “Эвлэрлийн гэрээ” гэж Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т зааснаар;

3.2. Энэ зүйлд тусгайлан заагаагүй бусад нэр томъёог Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол Улсын хуульд зааснаар ойлгоно.

4 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, зарчим

4.1.Эвлэрүүлэн зуучлалын зорилго нь талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олоход нь зуучлагч дэмжлэг үзүүлж, тэдгээрийн хоорондын харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай зохицуулахад оршино.

4.2.Эвлэрүүлэн зуучлалыг дараах зарчимд үндэслэн явуулна:

4.2.1.талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих;

4.2.2.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;

4.2.3.эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх;

4.2.4.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлэх

Дөрөвдүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг зохицуулах хүсэлт гаргах

4.1. Эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг зохицуулахаар аль нэг тал хүссэн эсхүл талууд харилцан тохиролцсон тохиолдолд өргөдлөө Төвд бичгээр гаргана. Өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

4.1.1.талууд эсхүл тэдгээрийн төлөөлөгчийн оноосон нэр, хаяг болон холбоо барих бусад мэдээлэл;

4.1.2.маргааны үндэслэл;

4.1.3.маргааны үнийн дүн;

4.1.4.эвлэрүүлэн зуучлалын журмаар маргааныг зохицуулах талаарх санал;

4.1.5. эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлэх газар, хэл, хугацааны талаарх санал;

- 4.1.6. эвлэрүүлэн зуучлагчид тавих шаардлагын талаарх санал;
- 4.2. Өргөдлөө бичгээр гаргах бөгөөд хүсэлт гаргасан тал, түүнийг төлөөлж буй этгээд гарын үсгээ зурсан байна.
- 4.3. Эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг зохицуулахаар талууд харилцан тохиролцсон тохиолдолд талуудын бичгээр хийсэн хэлцлийг өргөдөлдөө хавсаргана.
- 4.4. Талуудын аль нэг нь маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар зохицуулахыг хүссэн тохиолдолд хүсэлт гаргасан тал бусад талуудад мэдэгдэнэ.
- 4.5. Хүсэлт гаргаж байгаа тал эсхүл талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэхээс өмнө хураамж төлсөн байна.

5 дугаар зүйл. Хүсэлтийг хүлээн авах

- 5.1. Төв нь хүсэлтийг хүлээн авч өргөдөл болон түүнд хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг минутыг бүртгэнэ.
- 5.2. Аль нэг тал хүсэлт гаргасан тохиолдолд Төв нь өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор бусад талд энэ тухай мэдэгдэж, өргөдлийн хуулбар, түүнд хавсаргасан материалыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтын хамт хүргүүлнэ.
- 5.3. Талууд эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг зохицуулахаар харилцан тохиролцож төвд хүсэлтээ гаргасан, эсхүл аль нэг талын гаргасан хүсэлтийг бусад тал зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхэлсэнд тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх

Тавдугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч

- 5.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч нь маргааны талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд болон бусад этгээд байна.
- 5.2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хоёр ба түүнээс дээш тал, нэг буюу хэд хэдэн зуучлагч оролцож болно.
- 5.3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.
- 5.4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч болон бусад этгээдийн туслалцаа авч болно.
- 5.5. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмгөөлөгч болон гуравдагч этгээд оролцох тохиолдолд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 15, 16 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

6 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талуудын бүрэн эрх

6.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талууд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох, эвлэрүүлэн зуучлагчийн бүрэн эрх

Долоодугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох журам

7.1. Талууд нэг ажиллагаанд нэг, эсхүл хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагчийг сонгож болно.

7.2. Энэ журмын 7.1-д заасны дагуу хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагч сонгосон бол зуучлагчид дотроосоо ахлах зуучлагчийг сонгоно.

7.3. Талууд Төвөөс санал болгосон эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтаас сонгох бөгөөд тусгай мэргэжил, дадлага, туршлагатай эвлэрүүлэн зуучлагч шаардлагатай тохиолдолд Төвөөс санал болгосноос өөр эвлэрүүлэн зуучлагч сонгож болно.

7.4. Талууд эвлэрүүлэн зуучлагч сонгож чадаагүй бол Төв нь талуудтай зөвшилцсөний үндсэн дээр эвлэрүүлэн зуучлагчийг томилно.

7.5. Төвөөс эвлэрүүлэн зуучлагчийг томилохдоо талуудын тодорхойлсон шалгуурыг харгалзан үзнэ.

7.6. Талуудын томилсон эвлэрүүлэн зуучлагчийг Төвийн дарга батлахаас өмнө эвлэрүүлэн зуучлагч тухайн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар зохицуулахдаа бие даан, хараат бус байх зарчмаар ажиллахаа баталгаажуулан мэдүүлэгт гарын үсэг зурж, хараат бус байдалд нь эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдлын талаар бичгээр тайлбар гаргана.

7.7. Төв энэ журмын 7.6-д заасан мэдээллийг талуудад бичгээр мэдэгдэж хариу тайлбар өгөх хугацаа олгоно.

7.8. Эвлэрүүлэн зуучлагчийг томилсоны дараа илэрхий болсон үндэслэлээр талууд түүнийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргаж болох бөгөөд үүнийг Эвлэрүүлэн зуучлалын тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлагчийн бүрэн эрх

8.1. Эвлэрүүлэн зуучлагч Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

8.2. Талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг Төвийн дарга батлах бөгөөд талуудын зүгээс эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах эсхүл хараат бус байдалд нь эргэлзээ төрүүлж болохуйц нөхцөл байдлын талаар бичгээр тайлбар гаргаагүй байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Есдүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газар

9.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааг уг ажиллагааны хаалттай явагдах зарчмыг хангах боломжтой газарт явуулна.

9.2. Талууд харилцан тохиролцоогүй бол Төв нь эвлэрүүлэн зуучлагч болон талуудын биечлэн уулзах газрыг тодорхойлох, эсхүл эвлэрүүлэн зуучлагчид уг газрыг тодорхойлох санал тавьж болно.

Аравдугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа

10.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хугацааны дотор явуулна.

Арван нэгдүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах журам

11.1. Эвлэрүүлэн зуучлагч болон талууд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дэг, журмыг хамтран хэлэлцэж тодорхойлно.

11.2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтаар эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дэг, журам, талуудын эрх, үүргийг танилцуулж, талуудын шаардлага, тайлбарыг сонсож, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлно.

11.3. Талууд эсрэг талдаа мэдэгдэхгүйгээр зуучлагчтай уулзах, тухайн маргаанд өмгөөлөгчөөр ажиллах талаар эвлэрүүлэн зуучлагчид хүсэлт, шаардлага тавих зэрэг хууль бус үйлдэл, эс үйлдэхгүйгээр эвлэрүүлэн зуучлагчийн төвийг сахисан байр суурийг алдагдахуйц үйлдэл хийхийг хориглоно.

11.4. Эвлэрүүлэн зуучлагч өөрийн ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийг ажил үүргээ гүйцэтгэж байх үед болон бусад үед задруулж үл болно.

11.5. Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж авсан баримт сэлтийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

11.6. Хуульд зааснаас бусад тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагчийг гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй.

11.7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үед талуудын гаргасан аливаа тайлбар нь арбитраар маргааныг хянан шийдвэрлэхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй.

11.8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудыг хамтран оролцуулах зарчмын дагуу явуулах бөгөөд эвлэрүүлэн зуучлагч зөвхөн шаардлагатай тохиолдолд талуудтай ганцаарчилсан уулзалт хийнэ.

Арван хоёрдугаар зүйл. Тэмдэглэл

12.1. Эвлэрүүлэн зуучлагч буюу түүний даалгавраар эвлэрүүлэн зуучлах ажилтан ажиллагаа бүрийн тэмдэглэлийг цаг тухайд нь хөтөлнө.

12.2. Тэмдэглэл хөтлөх, хадгалах, хамгаалахтай холбоотой харилцааг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

Арван гуравдугаар зүйл. Эвлэрлийн гэрээ

13.1. Талууд болон зохигчид эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрэх, шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, шаардлага болон нэхэмжлэлээсээ татгалзах замаар эвлэрлийн гэрээ байгуулна.

13.2. Талуудын тохиролцооны агуулгыг талууд өөрсдөө, эсхүл тэдний хүсэлтээр эвлэрүүлэн зуучлагч нэгтгэн тусгасан эвлэрлийн гэрээний төслийг боловсруулна.

13.3. Эвлэрлийн гэрээ нь Иргэний хууль болон Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

13.4. Эвлэрлийн гэрээг хоёр тал хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах

14.1. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Эвлэрүүлэн зуучлалын хураамж, зардал

Арван тавдугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, зардал

15.1. Эвлэрүүлэн зуучлагчаас маргаан зохицуулахтай холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө талууд болон зохигчдоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж гэнэ.

15.2. Эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлсийг талууд гэрээгээр тохиролцоно.

Арван зургаадугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийн хэмжээ

16.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийн хэмжээг маргааны үнийн дүнгээс доорх хэмжээгээр тогтооно:

/төгрөгөөр/

№	Маргааны үнийн дүн	Хураамж /Тал тус бүр/
1.	0 – 10 000 000	350 000

2.	10 000 001-50 000 000	450 000
3.	50 000 001- 100 000 000	550 000
4.	100 000 001 – 500 000 000	650 000
5.	500 000 001-ээс дээш	800 000

16.2. Эдийн бус, үнэлэх боломжгүй маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж 300'000 төгрөг байна.

Арван долоодугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал, хураамжийг төлөх

17.1. Эвлэрүүлэн зуучлуулах өргөдөл гаргасан этгээд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийг хуульд заасны дагуу урьдчилан төлнө.

17.2. Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал, хураамжийг Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын дансанд шилжүүлснээр төлсөнд тооцно.

17.3. Маргааны үнийн дүн гадаад улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд түүнийг өргөдөл гаргах үеийн Монгол банкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож төлнө.

17.4. Маргааны үнийг талууд мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй тохиолдолд Төв тухайн маргааны үнийн дүнг тодорхойлно.

17.5. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад аль нэг талын хүсэлтээр нэмэлт зардал гарсан тохиолдолд хүсэлт гаргасан тал, хүсэлтийг хамтран гаргасан тохиолдолд хувь тэнцүүлэн төлнө.

17.6. Төв эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал болон эвлэрүүлэн зуучлагчийн ажлын хөлсийг ажиллагаа эхлэхээс өмнө энэ журмын 17.2-т заасан дансанд байршуулахыг талуудаас шаардаж болно.

17.7. Энэ журмын 17.6-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг цуцлах эрхтэй.

17.8. Энэ журмын 17.5-д зааснаас бусад тохиолдолд болон талууд өөрөөр тохиролцоогүй бол аливаа зардал, хураамжийг талууд тэнцүү хэмжээгээр төлнө.

Арван наймдугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамжийг буцаан олгох

18.1. Аль нэг тал эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцохоос татгалзсан, эсхүл эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон, дурьдсан хаягт оршин суудаггүй болох нь тогтоогдож эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдах боломжгүй болсон тохиолдолд хураамжийг буцаан олгоно.

18.2. Буцаан олгох төлбөрт хүү тооцохгүй.

18.3. Хураамжийг энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд буцаан олгохгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Бусад

Арван есдүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болох

19.1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр талуудын хүсэлт болон эвлэрүүлэн зуучлагчийн санаачилгаар эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг дуусгавар болгож болно.

19.2. эвлэрүүлэн зуучлагч өөрийн хүчин зүтгэлээр талуудыг эвлэрэлд хүргэж чадахгүй гэж үзсэн бол талуудын санал, зөвшөөрлийн дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгох эрхтэй.

Хорьдугаар зүйл. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах

20.1. Эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол гэрээний гүйцэтгэлийг хангуулахаар нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

Хорин нэгдүгээр зүйл. Журам хүчин төгөлдөр болох

21.1. Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

----oOo----